



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 26

Алтай

┌ Дахин дуудлага худалдаа явуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 35, 78, 97 дугаар тогтоолуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. 2015 оны хувьчлах хөрөнгийн жагсаалтад хувьчлахаар батлагдсан боловч нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авах санал ирээгүй Есөнбулаг сумын 5-р цэцэрлэгийн хуучин барилгыг өмнө тогтоосон үнийг 20 хувиар бууруулан дахин дуудлага худалдаа явуулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьчлагдаж буй өмч хөрөнгийн хувьчлагдах хүртэлх хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулж, дахин дуудлага худалдааг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явуулж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/, Орон нутгийн өмчийн албаны дарга /Л.Ганхуяг/ нарт даалгасугай.

ДАРГА



А.ДЭЛГЭРЖАРГАЛ